

БАТЛАВ
ЗАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГА *Д.Мөнхнасан* Д.МӨНХНАСАН
2020 оны 03 сарын 06 өдөр
6419278481
9008258 ГСТ6210

ЗАГ СУМЫН “ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР”

Огноо: 2020.03.06

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРНЫ ХҮҮХДИЙН ХООЛ ХҮНСНИЙ МАТЕРИАЛ
НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Гэрээний нэр: Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүүхдийн хоол,
хүнс нийлүүлэх.

Гэрээний дугаар: БХАЗСЗДТГ/2020030612

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

[Баянхонгор аймгийн Заг сумын Засаг даргын Тамгын газар] нь эрх бүхий тендерт оролцогчдоос **Заг сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүүхдийн хоол, хүнсний материал нийлүүлэх /БХАЗАГ/2020030512-ийг** нийлүүлэх тухай цахим худалдан авах системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг өөрийн аж ахуй нэгжийн цахим гарын үсэг, хувийн нууцлалын кодоор www.tender.gov.mn сайтад нэвтэрч цахимаар **[2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 11 цаг 00 минут]**-аас өмнө **[Заг сумын Засаг даргын Тамгын газар Санхүүгийн албаны өрөө]** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэнд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[2020 оны 03 дугаар сарын 20]-ны өдрийн [11цаг 30 минут]-д** Сумын Санхүүгийн албаны өрөөнд нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендерийн баримт бичгийн үнэ төлөөгүй бол тендерт гүйцэтгэгчээр сонгон шалгаруулахгүй байх үндэслэл болно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно

Заг сумын Засаг даргын Тамгын газар
(Санхүүгийн албаны өрөө 88059653, 80800498
утсаар холбогдоно)

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч | <p>1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</p> |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | <p>2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.</p> <p>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.</p> <p>2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</p> |
| 3. Тендерийн иж бүрдэл | <p>3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:</p> <ul style="list-style-type: none"> (а) Үнийн санал; (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь; (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг; (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл; (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана. |
| 4. Тендерийн үнэ | <p>4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.</p> |

- 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
- 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
- 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1.	<p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Санхүүгийн тайлан ирүүлэх: 2018 оны Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, 2019 оны санхүүгийн тайлан 2. Энэхүү тендерийн бичиг баримтад тусгагдсан жишиг маягтын дагуу гаргаж баталгаажуулсан үнийн санал ирүүлэх. 3. Бараа нийлүүлэх хугацаа, график ирүүлэх. 4. Улсын бүртгэлийн гэрчилгээг нотариатаар баталгаажуулсан хуулбар, үйл ажиллагааны чиглэл нь хүнсний дэлгүүрийн худалдаа эрхэлдэг байх. /тохирлын гэрчилгээ/ 5. Урт хугацааны болон хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаар Монгол банк болон харилцагч банкнуудаас тодорхойлолт ирүүлэх. 6. Татварын байгууллагын тодорхойлолт / Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байх / 7. НДаатгалаас өр төлбөргүй тухай тодорхойлолт ирүүлэх /НДаатгалын дэвтэрийн хуулбар, Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байх/ 8. Борлуулалтын хэмжээ: 2018-2019 оны борлуулалтын орлогын нийт мөнгөн дүн санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх. 9. Урьд өмнө ижил төстэй ажил гүйцэтгэгчээр сүүлийн 2 жил гүйцэтгэсэн бол захиалагчийн гэрээг дүгнэсэн дүгнэлийг ирүүлэх. <p>Б.Хэрэв урьд өмнө ижил төстэй ажил гүйцэтгээгүй бол хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтын дагуу өрсөлдөх тэгш боломжоор хангах.</p>

10. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ болон авах боломжит зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй эргэлтийн хөрөнгийн эх үүсвэртэй байх.
11. Тендерт оролцогч нь малын гаралтай болон гурилан бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ.
12. Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: Хүнсний эрхийн бичиг авах эрх үүссэн өрхийн гишүүн иргэдэд нийлүүлэх 10-н нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн нь хүнсний аюулгүй байдлыг бүрэн хангасан, хадгалалт хамгаалалтын стандартын горимын дагуу нөөцлөх, агуулах скалад, хөргүүр, тээврийн хэрэгсэл зэргийг өөрийн болон түрээсээр эзэмшидэг тухайгаа нотлох баримтаар ирүүлэх.
13. Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: Гэрээт хугацаанд нийлүүлэгдэх бүх бараа нь эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан зориулалтын сав баглаа, боодолтой, тээвэрлэлтийн үеийн гэмтлийг буцаах, солиулах, хугацаа хэтэрсэн дохиолдолд буцаах зэрэг тодорхойлолтыг албан бичгээр ирүүлэх.
14. Татвар, төлбөр, хураамж төлсөн эсхийг тендер нээсэн өдрөөр тооцно. Татвар, нийгмийн даатгал, банк, болон бусад байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөртэй, ял шийтгэлтэй болох нь холбогдох байгууллагуудаас ирүүлсэн тодорхойлолтоор нотлогдсон тохиолдолд тендерээс татгалзах үгдэслэл болно.
15. ТШӨХ-д заасан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.
16. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийн дагуу материалыг эмх цэгцтэй харагдахуйц тод бэлтгэж ирүүлэх. /Ирүүлсэн материалын харагдах байдал хангалтгүй тохиолдолд тухайн материалыг хангалтгүйд тооцож үнэлгээнд харгалзахгүй/

	Сахүүжилтийн эх үүсвэр нь: Улсын төсвийн хөрөнгөөр
ТӨӨЗ 2.1.	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: [Заг сумын Засаг даргын Тамгын газар /Санхүүгийн албаны өрөө 88059653, 80800498/ Утсаар холбогдоно] Огноо: 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Цаг: 11 цаг 00 минутанд
ТӨӨЗ 2.1	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Давхар болон өрөөний дугаар: [Заг сумын Засаг даргын Тамгын газар /Санхүүгийн албаны өрөө] Огноо: 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн Цаг: [11 цаг 30 минут]
	Энэхүү тендер шалгаруулалт нь /дараах багц-1/-ээс бүрдэнэ.

ГУРАВ:ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

БАРАА НИЙЛҮҮЛЭЛТЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт стандарт: Заг сумын Сургуулийн дотуур байрны хүүхдийн хоол хүнсний бүтээгдэхүүнд нийлүүлэгдэх бүх бараа, бүтээгдэхүүн нь Монгол Улсын Хүнсний тухай хууль болон хүнсний аюулгүй байдлын тухай хууль, холбогдох стандартад нийцсэнийг нотлох баримт хавсаргасан байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.

2. Сав, баглаа боодол: Бараа тус бүр эрүүл ахуйн стадарт шаардлага хангасан зориулалтын сав баглаа боодолтой байх. Мах махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн болон хүнсний ногоо, жимс жимсгэнэ, гурилан бүтээгдэхүүний баталгаат хугацааны эхлэх, дуусах огноо тодорхой заасан байна. Тээвэрлэлтийн үеийн гэмтлийг буцаах, солиулах, хугацаа хэтэрсэн тохиолдолд буцаах.

3. Бараа хүргэх газар: Заг сумын Сургуулийн аж ахуйн скалад

4. Сонгон шалгаруулах барааны жагсаалт: Жилийн нийт дүнгээр

БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

№	Барааны нэр тодорхойлолт	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Бүтээгдэхүүн нийлүүлэлтийн хуваарь		Шалгуур үзүүлэлт
				2020 оны 01 дүгээр сарын 20-с 2019 оны 06	2020 оны 09 дүгээр сарын 01-ээс 2019 оны 12 дугаар сарын 31-ны	
Нэг. Мах махан бүтээгдэхүүн						
1	2	3	4	5	6	7
1	Үхэрийн мах	Кг	1500	750	750	Орон нутгийн үхэрийн чанартай, хатаж хуурайшаагүй, шинэ мах нийлүүлэх
2	Хонины мах	Кг	2200	1100	1100	Орон нутгийн хонины чанартай, шинэ мах нийлүүлэх
3	Тахианы мах	кг	43	21	22	Монгол тахианы мах хадгалат хамгалалтын горим алдагдаагүй баталгаат хугацаатай байх
Хоёр. Гурил гурилан бүтээгдэхүүн						
1	1-р гурил	кг	2000	1000	1000	Улаанбаатар 1-р гурил
2	Гоймон /Лавша/	кг	50	25	25	Хугацаа дуусаагүй, чанарын баталгаатай хаяг шошготой байх.
3	Гоймон /мушгиа/	кг	50	25	25	Чанартай хадгалалтын горим алдагдаагүй, хадгалах хугацаа тодорхой, хайг шошго бүтэн байх
4	Талх /торлон жижиг/	ш	200	100	100	Орон нутагт үйлдвэрлэсэн Эрүүл ахуйн шаардлага хангасан. Ширхэг, зүсэм нь 50гр-аас доошгүй жинтэй, амт чанартай, хадгалалтын горим алдагдаагүй, чанарын шинжилгээнд хамрагдсан, үйлдвэрийн хаяг шошго, хадгалах хугацаа тодорхой заасан байх.
5	Талх /буриад том/	ш	100	50	50	
6	Аарцтай боов	уут	100	50	50	
7	Сtimo боов	уут	100	50	50	
8	Торлон зөөлөн боов	уут	100	50	50	
9	Еэвэн /торлон/	уут	100	50	50	
10	Та чи боов	уут	100	50	50	
Гурав. Төмс хүнсний ногоо						
1	Төмс	кг	1600	800	800	Эх орны хөрсөнд ургасан шинэ ургацын, хадгалалтын горим
2	Сармис	кг	20	10	10	
3	Байцаа	кг	900	450	450	

4	Манжин	кг	500	250	250	хангасан, өт хорхойд идэгдээгүй, ялзарч муудаагүй байна. Мөн гарал үүсэл шинжилгээний бичигтэй байна.
5	Лууван	кг	763	381	381	
6	Сонгино	кг	100	50	50	
7	Чинжүү	кг	100	50	50	
8	Мөөг	кг	15	7	8	
9	Эрдэнэ шиш	Ш	5	2	3	Хадгалалтын горим алдаагүй хугацаа тодорхой байх.
10	Вандуй	ш	5	2	3	
11	Далайн байцаа	ш	20	10	10	Хятад улсад үйлдвэрлэгдсэн шөлний байцаа
Дөрөв. Жимс жимсгэнэ цагаан идээ						
1	Чацаргана	кг	80	40	40	Орон нутагтаа тариж ургуулсан амт чанартай байх.
2	Алим	кг	15	8	7	Монгол улаан алим, хадгалалтын стандартад нийцсэн муудаагүй шинэ байх
3	Үзэм	кг	30	15	15	Хадгалалтын горим алдаагүй. Орос улсад үйдвэрлэсэн сайн чанарын бор, ногоон үзэм
4	Сүү	л	500	250	250	Орон нутгийн малчидаас бэлтгэсэн, гарал үүсэл шинжилгээний бичигтэй, зохисгүй амт үнэргүй байх.
5	Тараг	л	100	50	50	
6	Аарц	кг	200	100	100	
7	Ааруул /чихэртэй/	кг	10	5	5	
8	Ааруул /чихэргүй/	кг	20	10	10	
9	Зөөхий	кг	20	10	10	
Тав.Бусад						
1	Шар будаа	кг	10	5	5	Чанарын баталгаатай хаяг шошготой, хугацаа дуусаагүй байх. /Слава брэнд, дүйцхүйц/
2	Цагаан будаа	кг	300	150	150	
3	Гурвалжин будаа	кг	200	100	100	
4	Мовёс /жимстэй, шоколдтай/	ш	30	15	15	Монгол Улсад үйлдвэрлэсэн Хугацаа дуусаагүй, чанарын баталгаатай хаяг шошготой байх.
5	Цай /Алх хадуур/	ш	15	8	7	Баталгаатай хаяг шошготой, хугацаа дуусаагүй хөвсгөл, Тайга цайтай дүйцхүйц.
6	Цай /Хөвсгөл/	ш	10	5	5	
7	Давс	кг	88	44	44	Монгол цагаан давс
8	Хөөлгөгч /500гр-тай/	ш	10	5	5	Хугацаа дуусаагүй, чанарын баталгаатай хаяг шошготой байх.
9	Элсэн чихэр	кг	100	50	50	Украин улсын чанартай элсэн чихэр. Хаяг шошготой баталгаат хугацаатай байх
10	Амтлагч /шөлтэй хоол/	ш	100	50	50	Баталгаат хугацаатай, хаяг шошготой монголд үйлдвэрлэгдсэн байх.
11	Амтлагч /Бууз, хуурга/	ш	150	75	75	
						Хугацаа дуусаагүй, чанарын баталгаатай хаяг шошготой байх.

12	Пүнтүүз	ш	50	25	25	
13	Сода	ш	10	5	5	Хүнсэнд хэрэглэгдэх шаардлага хангасан
14	Оливын тос	ш	50	25	25	Хаяг шошготой сайн чанарын, хугацаа дуусаагүй байх.
15	Шар тос	кг	28	14	14	Орон нутгийн малчидаас бэлтгэсэн, гарал үүсэл шинжилгээний бичигтэй, зохисгүй амт үнэргүй байх.
16	Масль	ш	19	9	10	Малчидын гар дээр бэлтгэсэн чанартай үнэргүй байх.
17	Варень	ш	100	50	50	Монголд үйлдвэрлэсэн хадгалах горим алдагдаагүй баталгаатай бүтээгдэхүүн байх.
18	Жимсний хатаамал	ш	20	10	10	

Жич: Тендерт оролцогч нь маягтаар ирүүлсэх үнийн саналдаа дээрхи барааны нэгжийн болон нийт үнийн дүнг тодорхойлон ирүүлнэ.

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[Огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийн тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн
1	2	3	4	5	6
Тендерийн нийт үнэ					

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаар хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг /утас/ факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
Бусад				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл /ГТН/-д эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээх гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа /0/ жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй |

- оруулах
7. Төлбөр 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэл хүлээн авснаас хойш /14/ хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтонд заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээ-гээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших /ГЕН-1/ 1.1. Нийлүүлэгдэх барааг Ерөнхий боловсролын сургуулийн холбогдох ажилтан чанар байдлыг шалган тоолж зарлагын баримт нэхэмжлэх, санхүүгийн баримтаар хүлээн авч баталгаажуулна.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт /ГЕН-2/ 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
1. Нийлүүлэгчийн барааны нэр, тоо хэмжээ, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь
2. Барааг хүргэсэн тухай баримт болон тээврийн баримт
3. Үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ
4. Барааны гарал үүслийн гэрчилгээ.
Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар /ГЕН-5/ 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага
(Гэрээний ерөнхий нөхцлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх ш шаардлага гарвал энд тусгана)
4. Төбөр /ГЕН-7/ 7.1 Гэрээний ерөнхий нөхцлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн /100/ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.

5. Алданги оногдуулах /ГЕН-9/ 9.1. Алданги оногдуулах хувь: /0,5 хувь/
Алдангийн нийт дүн: /10 хувь/

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт гэрээний дугаар]

.....хот/аймаг

Нэг талаас [Захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид ‘нийлүүлэгч’ гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын ____ –ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1.Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2.Захиалагч нь [гэрээний нэр, дугаар] –г (цаашид “бараа” гэх) [гэрээний үийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэд болно.

3.Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4.Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны ___ дугаар сарын ___ -наас _____ оны ___ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5.Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно цаашид “гэрээний баримт бичиг” гэх Үүнд:

- Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- Бусад шаардлагатай баримт бичиг
- Үнийн санал
- Гэрээний тусгай нөхцөл

Гэрээний ерөнхий нөхцөл
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь
Санхүүжилтийн хуваарь

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгийн буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]